



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 8/713

Арвайхээр

### Г Нууц хамгаалах ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 30 дугаар зүйлийн 30.4, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 2.1, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын нууц хамгаалах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд: -Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн  
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын бичээч

Нарийн бичгийн дарга: -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Байгууллагын нууц хамгаалах журмыг боловсруулан батлуулж, ажлын хэсгийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод нууц хамгаалах чиг үүргийг тусган, Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад шийдвэрийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ‘ахлагч (Ц.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101569

D:My Doc. Zahiramj. Zasag darga